



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/771

Улаанбаатар хот

Төсвийн хуваарьт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр, 2023 оны 134 дүгээр тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хотын шуудын 2023 оны төсвийн орлогын тодотгосон төлөвлөгөөний сарын хуваарь”-ийг 1 дүгээр, “Хотын шуудын 2023 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сарын шинэчилсэн хуваарь”-ийг 2 дугаар, “Нийслэлийн 2023 оны төсвийн төсөв хоорондын харилцааны сарын шинэчилсэн хуваарь”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг хянан олгохыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Төсвийн хуваарь батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 дугаар, “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/666 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



1110203398

